



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 15 өдөр

Дугаар А/207

Сүхбаатар сум


Аян зохион байгуулах тухай

Монгол Улсын Хилийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 149 дүгээр зарлигаар батлагдсан “Улсын хил хамгаалалтад иргэдийг оролцуулах журам”-ын 3 дугаар бүлгийн 1 дүгээр зүйл, аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.10, аймгийн Засаг дарга, сумдын Засаг дарга нартай байгуулсан гэрээний 2.23 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хил хамгаалах албыг бэхжүүлэх, хил хамгаалалтад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд “Нэг мянгат малчин-нэг агт” аяныг иргэд, олон нийтийн санал санаачлагд тулгуурлан зохион байгуулж, эх орныхоо хилийн халдашгүй дархан байдлыг сахиулах, хил хамгаалах ариун үйлсэд агт, уналгаар дэмжлэг үзүүлэх, ажлыг Хилийн 0101, 0243 дугаар ангиудтай хамтран 7-10 дугаар сард багтаан зохион байгуулахыг сум, багийн Засаг дарга нарт даалгасугай.
2. Аян зохион байгуулах ажлыг удирдлага, зохицуулалт, хяналтаар хангаж дүнг нэгтгэн 2020 оны 10 дугаар сарын 25-ны дотор танилцуулахыг аймгийн Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн Нарийн бичгийн дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ө.Сувдаа/-д үүрэг болгосугай.
3. Сумдын хилийн ангиудтай хамтран ажиллах хуваарийг хавсралтаар баталсугай.
4. Эх орныхоо хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хил хамгаалах үйлсэд туслах энэхүү аянд идэвх, санаачилгатай оролцохыг аймгийн нийт иргэд, аж ахуй нэгж, байгууллагад уриалсугай.

ЗАСАГ ДАРГА

Ш.ОРГИЛ



C:\users\albanbichig2020\zahiram_A4.docx

420801007